

## МОНГОЛ СЕКЬЮРИТИЕС ҮЦК” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

Монгол улсын компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9, 62.1.5 дахь заалтууд болон “Монгол Секьюритиес ҮЦК” ХК-ийн 2024 оны 05 дугаар сарын 23-ний өдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын дүнг үндэслэн ТОГТООХ НЬ:

1. “Монгол Секьюритиес ҮЦК” ХК-ийн 2023 оны хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг Компанийн тухай хуулийн 69.1-д заасныг үндэслэн ирц хангалттай тул хүчинтэй хэмээн үзсүгэй.
2. “Монгол Секьюритиес ҮЦК” ХК-ийн 2023 оны санхүүгийн тайлан тэнцлийн нийт хөрөнгийг 1,050,378,829.19 төгрөгөөр үүнээс эргэлтийн бус хөрөнгийг 3,320,897.78 төгрөгөөр, эргэлтийн хөрөнгийг 1,047,057,931.21 төгрөгөөр, нийт орлогыг 500,345.66 төгрөгөөр, алдагдалыг 56,039,845.65 төгрөгөөр тус тус тооцож тайлан тэнцлийг баталсугай.
3. Компанийн үйл ажиллагааны тайланг баталсугай.
4. 2024 онд үйл ажиллагааг эрчимжүүлж ашгийг нэмэгдүүлэн ажиллахыг Гүйцэтгэх захирал /Л.Гүндэгмаа/-д даалгасугай

ХУРЛЫН ДАРГА



Л.ГҮНДЭГМАА